Хавсралт 1

Гишүүн холбоодод зориулсан хамгааллын бодлогын загвар

Энэхүү баримт бичгийг хүүхэд болон насанд хүрэгчдийг хамгаалах чиглэлээр ажилладаг орон нутгийн байгууллагууд болон бусад байгууллагын зөвлөгөө, удирдамжийн дагуу боловсруулах шаардлагатай бөгөөд ингэснээр бодлого нь орон нутгийн соёлыг харгалзсан, түүнд нийцсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ нь гишүүн холбооны баталж, түүний гишүүд болон олон нийтэд ойлгомжтой баримт бичгийг боловсруулах хамгийн оновчтой арга юм. Гишүүн холбоо нь гишүүддээ өөрсдийн бодлого, журмыг боловсруулахыг үүрэг болгох эсэх, эсвэл үүнийг хийхийг тэдэнд хүчтэй уриалах эсэхийг шийдвэрлэх шаардлагатай. Энэхүү баримт бичгийн турш гишүүн холбооны нэрийг дөрвөлжин хаалтан [ ] дотор оруулна.

Агуулга

1. Оршил
2. Бодлогын амлалтын мэдэгдэл ба зарчим
3. Тодорхойлолт
4. Бодлогын үйлчлэх хүрээ
5. Санаа зовоосон асуудлыг мэдээлэх
6. Мэдээлэх үйл явцын схем
7. Ёс зүйн дүрэм
8. Ажилд авах
9. Сургалт ба боловсрол
10. Сахилгын журам
11. Хянан үзэх
12. Хяналт тавих

1 Оршил

[Гишүүн холбоо] нь (Улс)-д хөнгөн атлетикийг хөгжүүлэх, мөн хүүхэд болон насанд хүрэгчид авьяас чадвараа хөгжүүлж, зорилгодоо хүрэх аюулгүй орчин болгох үүрэгтэй. Эдгээр туршлага нь хөгжилтэй, таатай байх ёстой. Энэхүү Хамгааллын бодлого (цаашид “энэхүү Бодлого”) нь хүүхэд болон насанд хүрэгчид хөнгөн атлетикт аюулгүйгээр оролцох боломжийг хангахад [Гишүүн холбоо] болон [Клубүүд]-ийн хүлээх үүргийг тодорхойлно.

Энэхүү Бодлогыг мөрдөж, түүнд тусгагдсан шилдэг туршлагын зарчмуудыг сурталчлах нь гишүүн холбоонд өөрийн хамт олон хөнгөн атлетикаар хичээллэж, таашаал авах аюулгүй, аз жаргалтай, урам зориг өгөх орчныг бүрдүүлж, бий болгох боломжийг олгоно.

Хүчирхийллийг эрэгтэй, эмэгтэй эсвэл хүүхэд үйлдэж болно. Энэ нь дэлхийн өнцөг булан бүрт, спортын төрөл, байгууллага бүрт тохиолддог. Аль ч бүс нутаг түүний нөлөөллөөс ангид эсвэл хамгаалагдсан гэж өөрийгөө үзэх боломжгүй. Хүчирхийлэл, дарамт, мөлжлөг нь хүмүүсийн хооронд эрх мэдлийн тэнцвэргүй байдал үүссэн үед гардаг. Хэн нэгэн илүү хүчтэй байр суурьтай байх үед тэр байр сууриа буруугаар ашиглаж болох бөгөөд улмаар хүчирхийлэл, дарамт эсвэл мөлжлөг гарч болзошгүй. Нас, хөгжлийн бэрхшээл, санхүүгийн байдал эсвэл нөхцөл байдлаасаа шалтгаалан хүн хэдий чинээ эмзэг байна, төдий чинээ хүчирхийлэл, дарамт эсвэл мөлжлөгт өртөх магадлал өндөр байна.

2 Бодлогын амлалтын мэдэгдэл ба зарчим

[Гишүүн холбоо] нь хөнгөн атлетикт оролцож буй хүн бүрийг хүндэтгэлтэй, нэр төрийг нь хүндэлж харьцах ёстой бөгөөд хүн бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртөхгүйгээр оролцох эрхтэй гэж үздэг. [Гишүүн холбоо] нь энэхүү Бодлогын үйлчлэх хүрээнд хамаарах бүх хүнийг ийм зан үйлээс хамгаална. [Гишүүн холбоо] нь энэ эрх нь хүний гарал үүсэл, арьсны өнгө, нас, хөгжлийн бэрхшээл, хүйс, хүйсийн баримжаа, бэлгийн чиг баримжаа, угсаа гарал, шашин шүтлэг, үзэл бодлоос үл хамаарна гэж үздэг. [Гишүүн холбоо] нь энэхүү Бодлого хамаарах хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлж, хүн бүр чадвараараа спортод оролцож, таашаал авах аюулгүй орчныг бүрдүүлэх үүрэг хүлээнэ. Энэхүү Бодлого нь тамирчид, дасгалжуулагчид (тамирчдыг дэмжих бүх ажилтныг оруулан), шүүгч, албан тушаалтнууд, сайн дурын ажилтнууд болон удирдах зөвлөлийн гишүүдийг хамгаална. Тэд бүгд энэ чиглэлээрх өөрсдийн эрх болон үүргийг мэдэж байх ёстой.

Энэхүү Бодлого дараах зарчимд үндэслэнэ:

- Хүн бүр хүндэтгэлтэй, нэр төрийг нь хүндэлсэн харьцаанд байх эрхтэй бөгөөд хүйс, гарал үүсэл, нас, угсаа, чадвар, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, үзэл бодол, шашин болон улс төрийн харьяаллаар нь ялгаварлан гадуурхагдах ёсгүй.
- Хүн бүр аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөггүй, аюулгүй, хүртээмжтэй орчинд хөнгөн атлетикт оролцох, таашаал авах, түүгээр дамжуулан хувь хүний хувьд хөгжих эрхтэй.
- Хүүхэд ч бай, насанд хүрэгч ч бай хүн бүр сонсогдох эрхтэй, ялангуяа өөрийн эсвэл бусдын сайн сайхны талаар санаа зовнилоо илэрхийлэх үед. Хэн нэгний зан үйлийн талаар санаа зовж байвал хэнд хандаж тусламж авахаа хүн бүр мэдэж байх ёстой.
- Хүн бүр хүүхдийг асран халамжилж, хамгаалах, тэдний эрх ашгийг дээдлэн шийдвэр гаргах үүрэгтэй, учир нь тэдний сайн сайхан байдал нэн тэргүүнд тавигдана.

Үүний тулд [Гишүүн холбоо]:

- ✓ удирдах зөвлөлийнхөө гишүүд энэхүү Бодлогыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, энэхүү Бодлогын зарчмуудыг хөтөлбөрийнхөө бүх талд нэвтрүүлэх “Хамгааллын элч”-ийг томилно;
- ✓ хамгааллын үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий “Хамгааллын ажилтан” гэж нэрлэгдэх ажилтан эсвэл сайн дурын ажилтныг томилно;
- ✓ өөр хүн болон түүний зан үйлийн талаар санаа зовж буй тохиолдолд энэхүү томилогдсон ажилтан эсвэл сайн дурын ажилтанд хандаж болно гэдгийг хүн бүрд мэдүүлнэ;
- ✓ хүн бүр өөрийн эрх болон санаа зовнил илэрхийлэгдсэн тохиолдолд мөрдөх журмын талаар мэдлэгтэй байхыг хангана;
- ✓ ёс зүйн дүрэм, журам, сахилгын журам зэрэг бодлого, журмыг боловсруулж хэрэгжүүлэх ба шаардлагатай үед шинэчилнэ;
- ✓ санаа зовнилоо илэрхийлсэн, гомдол эсвэл мэдээлэл гаргасны дараа тусламж хэрэгтэй аливаа хүнд дэмжлэг, зөвлөгөө үзүүлнэ;
- ✓ бүх ажилтан, сайн дурын ажилтнуудад санаа зовнил, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар сургалт, боловсрол олгоно;
- ✓ бүх санаа зовнил, мэдээлэл, гомдлыг шударга, ил тод, үр дүнтэй, цаг тухайд нь шийдвэрлэж, гомдол гаргагчдад явцын талаар тогтмол мэдээлнэ;
- ✓ бүх мөрдөн шалгалт, сонсголыг зохих түвшний хараат бус байдлыг хангасан байдлаар явуулж, гарах тайлан эсвэл эрсдэлийн үнэлгээнд хэвийх хандлага гарахаас сэргийлнэ;
- ✓ санаа зовнил, гомдол эсвэл мэдээлэлтэй холбоотой бүх мэдээллийг (хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд) нууцалж, аюулгүй хадгална;
- ✓ ажилтан ч бай, сайн дурын ажилтан ч бай тохирох хүнийг тохирох албан тушаалд томилж, суурь мэдээллийг шалгаж, тодорхойлолтыг баталгаажуулан зөвхөн тохирох хүмүүсийг томилохыг хангана;
- ✓ хүн бүрийн аюулгүй байдлыг хангахын тулд нийгмийн халамжийн үйлчилгээний өмнөөс дэмжлэг, зөвлөгөө үзүүлдэг орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, иргэний бүлгүүдтэй хамтран ажиллана.

3 Тодорхойлолт

Хүчирхийлэл, дарамт ба мөлжлөг

Доор хүчирхийлэл, дарамт, мөлжлөгийн талаар тайлбарлав. Эдгээрийг эрэгтэй, эмэгтэй хэн аль нь ч үйлдэж болох бөгөөд нэг тал нөгөө талын нөхцөл байдлыг хянах эрх мэдэл бүхий байр суурьтай үед ихэвчлэн тохиолддог. Харилцаанд нэг хүн нөгөөгөөсөө илүү эрх мэдэлтэй байх үед хүчирхийлэл гарахад хялбар нөхцөл

байдал үүсч болно. Эрсдэлд бүй хүмүүсийг хамгаалах ёстой бөгөөд эрх мэдэл бүхий хүмүүс зохих хамгаалалтын арга хэмжээ авагдсан эсэхийг хангах ёстой. Түүнчлэн дасгалжуулагч, шүүгч эсвэл сайн дурын ажилтнууд өөрсдөө бусдын хүчирхийлэлд өртөж болохыг ойлгох нь чухал.

Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэг нь хүнийг гутаан доромжлох, басамжлах, үл тоох, хорих, тусгаарлах, үгээр дайрах, доромжлох, айлган сүрдүүлэх, хүүхэд мэт харьцах зэрэг аливаа хүсээгүй үйлдэл, эсвэл хүний өөрийгөө таних мэдрэмж, нэр төр, өөрийн үнэ цэнийг бууруулж болзошгүй бусад аливаа зан үйлийг хэлнэ. Эдгээр үйлдэл нь хүчирхийллийн ихэнх хэлбэрийн цөм болдог; эдгээр үйлдэл гарсан газар сэтгэл санааны хүчирхийлэл мөн тохиолддог. Энэ нь ихэвчлэн биечлэн дээрэлхэх эсвэл цахим дээрэлхэлт хэлбэрээр илэрч болно.

Бие махбодын хүчирхийлэл гэдэг нь өшиглөх, цохих, хазах, түлэх зэрэг гэмтэл, бие махбодын хохирол учруулах аливаа санаатай эсвэл хүсээгүй үйлдлийг хэлнэ. Үүнд архи уухыг албадах эсвэл системтэй допинг хэрэглүүлэх үйлдэл хамаарч болно. Мөн тамирчны нас, бие бялдарт тохироогүй бэлтгэл зэрэг албадсан эсвэл зохисгүй бие бялдрын үйл ажиллагаа байж болно. Тамирчид болон дасгалжуулагчдын хүсэл эрмэлзэл, түүнчлэн үе тэнгийнхний дарамт нь тамирчид, дасгалжуулагчид эсвэл аль алиныг нь хэт их бэлтгэлийн ачаалал болон/эсвэл тэмцээний үүрэг тулгах буюу тэвчихэд хүргэж болзошгүй тул спортын орчинд албадан эсвэл хэт их бэлтгэл хийлгэх нь анзаарагдахгүй байж болно. Тохиролцсон, хүрэх боломжтой амжилтын зорилт тавихад чиглэсэн тамирчид, дасгалжуулагчдын яриа хэлэлцээ нь хүлээн зөвшөөрөгдөхүйц, даах боломжтой бэлтгэлийн шаардлагыг тогтооход тусална. Тамирчны эрүүл мэнд, сайн сайхан байдалтай зөрчилдөж болзошгүй хүсэл эрмэлзлийг зохицуулах нь дасгалжуулагчдын үүрэг юм.

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь зөвшөөрөл өгөөгүй, зөвшөөрөл өгөх боломжгүй, эсвэл албадлага, хууран мэхлэлтээр зөвшөөрөл авсан нөхцөлд үйлдэгдсэн, биеийн хүрэлцээтэй (нэвтрэлттэй эсвэл нэвтрэлтгүй) эсэхээс үл хамааран бэлгийн шинжтэй аливаа үйлдлийг хэлнэ. Үүнд бэлгийн шинжтэй зураг үзэх эсвэл бүтээх, бэлгийн үйл ажиллагааг харах, бусдыг бэлгийн хувьд зохисгүй зан авир гаргахад өдөөх, эсвэл хүчирхийлэлд бэлтгэх зорилгоор хүнийг өөртөө татан уруу татах (груминг) зэрэг орж болно.

Груминг (уруу татах) гэдэг нь хэн нэгэн (онлайнаар эсвэл биечлэн) тамирчинтай харилцаа тогтоож, түүнийг өөртөө итгүүлэх замаар өөрийн ашиг сонирхлын төлөө тамирчныг хууран мэхэлж, мөлжих боломжтой болох үйл явцыг хэлнэ. Тамирчны гэр бүл, туслах ажилтнууд, найз нөхдийг уруу татах нь ихэвчлэн тэднийг уруу татагчийг найдвартай, итгэл төрүүлэхүйц хүн гэж итгэхэд хүргэж, улмаар тамирчинд ойртох боломжийг олгодог. Уруу татагч тамирчныг хууран мэхэлж, тэдний хоорондох харилцааг бурууган ашиглан тамирчинд өөрийнх нь шаардлагыг биелүүлэх ёстой гэж итгүүлдэг. Уруу татагчийн тамирчинд үзүүлэх эрх мэдлийг тамирчныг эдгээр шаардлагыг биелүүлэхээс сэрэмжлүүлж болох найз нөхөд, гэр бүлийн гишүүдээс нь тусгаарлахад ашигладаг.

Дарамт гэдэг нь хүнийг гомдоох, эсвэл доромжлогдсон, айсан мэдрэмж төрүүлэх хүсээгүй буюу таагүй зан үйлийг хэлнэ. Эрх мэдлийн дарамт нь эрх мэдэл бүхий хүн ихэвчлэн ажлын байранд тэр эрх мэдлээ ашиглан бие махбод эсвэл сэтгэл зүйн хувьд захирагдах байдалд буй өөр хүнийг дарамтлах үед гардаг. Эрх мэдлийн дарамтад гадуурхах, зохисгүй ажил оноох (хэт бага, хэт их, эсвэл хүлээн зөвшөөрөгдөх түвшнээс доогуур), мөн хувийн орон зайд халдах зан үйл хамаарч болно.

Бэлгийн дарамт гэдэг нь аман, аман бус эсвэл бие махбодын аль хэлбэрээр ч бай бэлгийн шинжтэй аливаа хүсээгүй буюу таагүй зан үйлийг хэлнэ. Аман бэлгийн дарамтын жишээнд хүний бие, хувцас, хувийн амьдралын талаарх хүсээгүй эсвэл доромжилсон дотно асуулт, бэлгийн далд утгатай хошигнол, зөвшөөрөлгүйгээр бэлгийн үйлдэл санал болгох эсвэл шаардах зэрэг орно. Эдгээрийг мессеж, утасны дуудлага, бичгэн мессеж эсвэл бэлгийн агуулга бүхий аливаа хүсээгүй харилцааны хэлбэрээр дамжуулж болно. Аман бус жишээнд ширтэх, дохио зангаа хийх, бэлгийн далд утгатай зураг хуваалцах зэрэг орж болно. Бие махбодын бэлгийн дарамтын жишээнд чимхэх, үнсэхийг оролдох, алгадах, хүрэх зэрэг бэлгийн шинжтэй шаардлагагүй биеийн хүрэлцээ орно.

Мөлжлөг гэдэг нь хэн нэгэн өөр хүний бүрэн мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөлгүйгээр “хувийн ашиг”-ийн төлөө тухайн хүн болон/эсвэл түүний өмч хөрөнгийг хянахыг хэлнэ. Хувийн ашиг нь сэтгэл зүйн, нэр хүндийн эсвэл арилжааны шинжтэй байж болох бөгөөд бусдын эрхийг түүний тодорхой илэрхийлсэн, бүрэн мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөлгүйгээр худалдах эсвэл хэлэлцээр хийх нь мөлжлөг болно. Хөнгөн атлетик дахь жишээнд тамирчны нас, иргэншлийг залилан хуурамчаар илэрхийлэх, тамирчны нэрийн өмнөөс залилан үйлдэл хийх, ивээн тэтгэлгийн орлого эсвэл санхүүжилтийн гэрээнээс үндэслэлгүй хувь авах зэрэг орно. Мөлжлөг олон янзын хэлбэртэй бөгөөд үүнд бэлгийн мөлжлөг, санхүүгийн мөлжлөг, тамирчдыг хүүхэд байх үед нь урт хугацааны гэрээ байгуулахад хүргэх зэрэг орно.

Хайхрахгүй байдал гэдэг нь бие махбодын эсвэл сэтгэл санааны хамгийн бага түвшний халамж үзүүлээгүйн улмаас хохирол учруулах, хохирол учрахыг зөвшөөрөх, эсвэл хохирол учрах ойрын эрсдэл бий болгохыг хэлнэ. Энэ нь ихэвчлэн эцэг эх эсвэл асран хамгаалагчийн хүүхдэд үзүүлэх халамжтай холбоотой боловч дасгалжуулагч эсвэл багийн ахлагчийн тамирчны өмнө хүлээх үүрэг зэрэг бусдыг асран халамжлах үүрэг бүхий бусад хүмүүст ч хамаарна. Үүнд өндөр температурт хангалттай ус, бага температурт тохирох хувцас, зохих хоол хүнс, байр, эсвэл аюулгүй тээврийн нөхцөл хангаагүй байх зэрэг орж болно.

Хүчирхийлэл, дарамт, мөлжлөг нь гарал үүсэл, шашин, арьсны өнгө, үзэл бодол, угсаа гарал, хүйс, хүйсийн баримжаа, бэлгийн чиг баримжаа, нас, хөгжлийн бэрхшээл, нийгэм-эдийн засгийн байдал, спортын чадвар эсвэл эдгээр шинжийн аливаа хослол дээр үндэслэж болно. Энэ нь ганц тусгаарлагдсан тохиолдол эсвэл цуврал тохиолдлууд байж болох бөгөөд биечлэн эсвэл онлайнаар, санаатай, хүсээгүй эсвэл албадан хийгдэж болно. Дээрэлхэх, доромжлох, хайхрахгүй байх нь бүгд дарамт, хүчирхийлэл эсвэл мөлжлөгийн өөр нэг тал бөгөөд энэхүү Бодлогын заалтын дагуу адилхан шийдвэрлэх ёстой.

Хүчирхийлэл, дарамт, мөлжлөгийн аливаа хэлбэр нь санхүүгийн хүчирхийллийн элемент агуулж болно. Хүнийг бусдад санхүүгийн ашиг авчрах боловч өөрт нь санхүүгийн хувьд ашигтай байх албагүй гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурахыг албадаж болно. Хэрэв тухайн хүн хүүхэд бол, хэрэв тэр хэн нэгэнд өөрийнхөө өмнөөс ажиллах эрх олгоогүй бол, эсвэл нягтлан бодогч, хуульч зэрэг хараат бус мэргэжилтнээс гэрээний нөхцөлийн үр дагаврын талаар зохих зөвлөгөө аваагүй бол албадлагын аливаа элемент нь хүчирхийлэл, дарамт эсвэл мөлжлөг болж болно.

Зарим үйлдэл нэг хүний хувьд хүчирхийлэл биш байж болох ч түүнд өртөж буй хүний эмзэг байдлаас шалтгаалан хүчирхийлэл эсвэл хор хөнөөлтэй байж болно. Энэ нь тухайн хүний нас, чадвар эсвэл эмзэг байдлын бусад хэлбэрээс шалтгаалж болно.

Хүчирхийлэл, дарамт, мөлжлөг нь ихэвчлэн итгэл хүлээсэн байр суурьтай хүний эрх мэдлээ урвуулан ашигласны үр дүн, өөрөөр хэлбэл нөлөө, хүч эсвэл эрх мэдэл бүхий хүн бусдын эсрэг эрх мэдлээ буруугаар ашигласны үр дүн байдаг. Энэ нь ихэвчлэн насны зөрүүтэй үед тохиолддог боловч үе тэнгийнхэн, өөрөөр хэлбэл ойролцоо насны хүмүүсийн хооронд ч гарч болно. Хүчирхийлэл тамирчдын хооронд, тэр ч байтугай дасгалжуулагч, шүүгч эсвэл хөнгөн атлетиктай холбоотой бусад аливаа хүмүүсийн хооронд гарч болно. Үүнийг заримдаа үе тэнгийнхний хүчирхийлэл гэж нэрлэдэг бөгөөд бусад төрлийн санаа зовнилын нэгэн адил шийдвэрлэх ёстой. Хүчирхийллийг эцэг эх, хань, ах эгч дүү зэрэг гэр бүлийн гишүүд ч үйлдэж болно.

> **Хүүхэд:** “хүүхэд” эсвэл “хүүхдүүд” гэсэн нэр томьёо нь 18 нас хүрээгүй хүн эсвэл хүмүүсийн бүлгийг хэлнэ.

> **Хамгаалал** гэдэг нь эрсдэлд буй хүмүүсийг, хүүхэд ч бай насанд хүрэгч ч бай, хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалах үйл явцыг хэлнэ. Хүн бүрийг хүндэтгэлтэй, нэр төрийг нь хүндэлж харьцдаг аюулгүй, найрсаг орчныг бий болгох нь хамгааллын гол цөм юм. Хөнгөн атлетикт оролцож буй хүн бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд болон насанд хүрэгчдийн туршлагын талаарх яриаг сонсох, асуудал гарсан тохиолдолд аюулгүй, бүрэн хариу арга хэмжээ авахыг идэвхтэй хангахад үүрэгтэй.

4 Бодлогын үйлчлэх хүрээ

Энэхүү Бодлого нь [Гишүүн холбоо] болон түүний тамирчид, шүүгч, ажилтнууд, мөн [Гишүүн холбоо]-той холбоотой бусад аливаа хүнд хамаарна. Үүнд шүүгч, албан тушаалтнууд, сайн дурын ажилтнууд, тамирчдыг дэмжих багийн гишүүд, эцэг эх, асран хамгаалагчид болон [гишүүн холбоо байрладаг улс]-д хөнгөн атлетиктай холбоотой аливаа хүн хамаарна. Энэхүү Бодлого хамаарах бүх хүн түүнийг мөрдөх үүрэгтэй. Дээр дурдсан хүмүүс энэхүү Бодлогыг зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авч болно.

5 Санаа зовоосон асуудлыг мэдээлэх

Хэн ч хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртөхгүй байхыг хангах нь хүн бүрийн үүрэг юм. Тиймээс хэн нэгэн хүүхэд эсвэл насанд хүрэгч аливаа хэлбэрээр хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртөж байна гэж сэжиглэж байгаа, эсвэл өөр хүний зан үйлийн талаар санаа зовж байгаа бол асуудлыг үнэлж, зохих ёсоор шийдвэрлэхийн тулд эдгээр санаа зовнилыг [Гишүүн холбоо]-ны хамгааллын ажилтанд мэдээлэх ёстой. Цагдаа эсвэл нийгмийн халамжийн үйлчилгээг оролцуулах шаардлагатай байж болох бөгөөд энэ тохиолдолд [Гишүүн холбоо]-ны хамгааллын ажилтан үүнийг хийж, шаардлагатай арга хэмжээг зохицуулна.


Хэрэв хэн нэгэн ноцтой хохирол амсах шууд аюулд байгаа бол яаралтай тусламжийн албанд нэн даруй мэдээлэх ёстой. Зарим тохиолдолд асуудлыг мэдээлэхээс өмнө тухайн хүний нас, сэтгэцийн чадварыг харгалзан түүний зөвшөөрлийг авах ёстой. Зөвшөөрөл өгөх чадвар нь 12 нас хүрээгүй хүүхэд, 12-18 насны хүүхэд, мөн хүүхэд болон насанд хүрэгчийн хооронд ялгаатай. Хэрэв тухайн хүн зөвшөөрөл өгөхөөс татгалзсан ч асуудлыг мэдээлэх үүрэг хэвээр байж болно. [Энэ нь орон нутгийн хууль тогтоомж эсвэл журмаар зохицуулагддаг асуудал байж болох тул энэхүү Бодлогод тусгах ёстой].

[Гишүүн холбоо]-д мэдээлэгдсэн санаа зовнил, мэдээлэл болон бусад асуудлыг тухайн асуудалтай ямар ч холбоогүй хүн мөрдөн шалгах ёстой. Хэрэв асуудал “бага түвшний санаа зовнил”-той холбоотой бол мөрдөн

шалгагч [Гишүүн холбоо]-ноос бүрэн хараат бус байх шаардлагагүй. Санаа зовнил эсвэл мэдээлэл хэдий чинээ ноцтой байна, түүнийг шалгаж буй хүн [Гишүүн холбоо]-ноос хараат бус байх шаардлага төдий чинээ өндөр байна. Хэрэв санаа зовнилыг цагдаад шилжүүлсэн бол цагдаа мөрдөн шалгалт явуулна. Ноцтой санаа зовнилын талаар [Гишүүн холбоо]-ны явуулах аливаа мөрдөн шалгалтыг шударга, мэргэжлийн түвшинд, аль болох шуурхай явуулахыг хангахын тулд [Гишүүн холбоо]-той холбоогүй, мөрдөн шалгалт явуулахаар гэрээгээр ажиллуулж буй хүн гүйцэтгэх ёстой.

6 Мэдээлэх үйл явцын схем

[Энэ бол орон нутгийн журмыг харгалзан тохируулах шаардлагатай ерөнхий схем юм.]



7 Ёс зүйн дүрэм

Гишүүн холбоо нь өөрийн ажилтнууд, удирдах албан тушаалтнууд болон байгууллагын удирдлагад оролцож буй бусад аливаа хүнд зориулсан ёс зүйн дүрэмтэй байх ёстой. Мөн дасгалжуулагч, тамирчид,

эмнэлгийн туслах ажилтнууд, шүүгч, арга хэмжээний зохицуулагчид зэрэг бусад бүлгийг харгалзан үзэх ёстой. Эдгээр дүрэм нь шаардлагын дагуу тусгай эсвэл ерөнхий байж болох бөгөөд холбогдох бүлгүүд дүрмийн талаар мэдэж, түүнийг мөрдөх амлалтаа баталгаажуулахыг шаардах нөхцөлтэй.

[Гишүүн холбоо] нь дараах ёс зүйн дүрэмтэй:

- Дасгалжуулагчдын ёс зүйн дүрэм
- Тамирчдын ёс зүйн дүрэм
- [[Гишүүн холбоо]-ны боловсруулахаар шийдвэрлэсэн бусад аливаа дүрэм]

Дээрх бүх ёс зүйн дүрэм нь бусадтай хүндэтгэл, тэгш байдал, шударга ёс, нэр төртэйгээр харьцахад төвлөрсөн бөгөөд хүн бүр үнэ цэнэтэй, хүндэтгэл хүлээх ёстой гэсэн зарчимд үндэслэсэн. Эдгээр нь хөнгөн атлетиктай холбоотой хүн бүрд [Гишүүн холбоо]-ны тэднээс хүлээж буй зан үйлийн талаар мэдээлэх зорилготой. Эдгээр дүрэм нь холбогдох бүлгүүдэд зориулсан аливаа сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг байх ёстой бөгөөд ингэснээр хүн бүр эдгээр дүрэм байгаа, [Гишүүн холбоо]-ны хүлээлт, мөн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд сахилгын арга хэмжээ авч болохыг мэдэж байна. Дүрмүүдийг холбогдох бүлгүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулсан бөгөөд тогтмол хянан үзнэ.

Ёс зүйн дүрмийг холбогдох бүлгүүдэд хүргүүлж, мэдээллийн самбар эсвэл вэбсайтад байршуулах, эсвэл гишүүнчлэл сунгах маягт зэрэг аливаа бичгийн баримт бичигт тусгана.

Хэрэв хэн нэгэн өөр хүн холбогдох ёс зүйн дүрмийг зөрчиж байгааг мэдвэл үүнийг мөрдөн шалгах болон сахилгын арга хэмжээ авах боломжтой санаа зовнил болгон хамгааллын ажилтанд шилжүүлэх ёстой. Хэрэв [Гишүүн холбоо] тусгай хамгааллын дүрэм хэрэглэдэггүй бол аливаа ёс зүйн дүрмийн зөрчлийг сахилгын журмын дагуу шийдвэрлэж болно.

8 Ажилд авах

Хүүхэдтэй ойр ажиллах шаардлагатай аливаа албан тушаалд ажилтан эсвэл сайн дурын ажилтнаар өргөдөл гаргасан бүх хүн суурь мэдээллийн шалгалт эсвэл гэмт хэргийн бүртгэлийн шалгалтад хамрагдах шаардлагатай. Бүх өргөдөл гаргагч ярилцлагад орж, хоёр тодорхойлогч хүний мэдээлэл өгөх бөгөөд томилогдсоны дараа танилцуулах сургалтад хамрагдана. Ярилцлагад өргөдөл гаргагч болон түүний туршлагын талаарх, мөн хамгааллын талаарх мэдлэгийнх нь талаарх асуултууд орно. Тодорхойлолтуудыг шалгах бөгөөд нэг нь одоогийн эсвэл өмнөх ажил олгогч, нөгөө нь өргөдөл гаргагчийн хүүхэдтэй эсвэл спортын салбарт ажилласан байдлыг мэддэг хүн байх ёстой. Танилцуулах сургалт нь сонгогдсон өргөдөл гаргагчийг өөрийн үүрэг, хариуцлагыг мэддэг, хамгааллын бодлого, журмын талаар мэдээлэлтэй байхыг хангана.

9 Сургалт ба боловсрол

[Гишүүн холбоо]-ны бүх ажилтан, сайн дурын ажилтан, шүүгч нар байгууллага дахь үүрэгт нь нийцсэн хамгааллын сургалтад хамрагдана. Хүүхэдтэй ажилладаг хүмүүс өөрсдийн асран халамжилж буй хүүхдийн өмнө хүлээх үүрэгтэй нь тусгайлан холбогдсон мэргэшсэн сургалтад хамрагдана.

Хамгааллын сургалтыг тогтмол зохион байгуулах ёстой [наад зах нь жил бүр эсвэл хоёр жил тутам].

10 Сахилгын журам

Энэхүү Бодлого болон [Гишүүн холбоо]-ны хамгааллын дүрмийн зөрчлийг [Гишүүн холбоо]-ны сахилгын журмын дагуу шийдвэрлэх бөгөөд нэмэлт зааварчилгааг уг журмаас авна.

11 Энэхүү Бодлогыг хянан үзэх

Энэхүү Бодлогыг жил бүр хянан үзнэ.

12 Хяналт тавих

Энэхүү Бодлого болон түүний хэрэгжилтэд [Гишүүн холбоо] эсвэл энэ үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэшилтэй хараат бус хамгааллын байгууллага шаардлагын дагуу тогтмол хяналт тавина.